ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 16 өдөр Дугаар А/06 Сайншанд

Хороодын хуралдааны тов тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Сэврэй сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны 10 дугаар захирамжаар батлагдсан "Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн дэг" -ийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хороодын хурлын товыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 цагаас Ёс зүйн хороог иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны танхимд, 16 цагаас Нийгмийн бодлогын хөгжлийн хороог иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны танхимд, Эдийн засаг, өмч, төсөв, санхүү, дэд бүтцийн хөгжлийн хороог Засаг даргын орлогчийн албан өрөөнд, Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн хөгжлийн хороог иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын албан өрөөнд тус тус хуралдуулахаар тогтоосугай.

2. Хороодын хурлыг цаг хугацаанд зохион байгуулан 2025 оны ажлын төлөвлөгөө, бусад холбогдох асуудлаа хэлэлцэхийг Хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4625001010